



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 01

Чингис хот

"Гайхамшигт хүмүүсийн дуу хоолой"
Хүүхдийн чуулганаас гарсан санал
хэрэгжүүлэх тухай

2022 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан "Гайхамшигт хүмүүсийн дуу хоолой" аймгийн хүүхдийн чуулганаас гарсан саналыг үндэслэн ДААЛГАХ нь:

"Гайхамшигт хүмүүсийн дуу хоолой" аймгийн хүүхдийн чуулганаас гарсан саналыг шийдвэрлэж, хэрэгжүүлэх зорилгоор хүүхдийн өмнө үүрэг хүлээгч талуудад даалгасугай.

НЭГ. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт

1.2 Аймгийн Хүүхдийн зөвлөлийн гишүүнчлэлийг бүрдүүлэх, зохион байгуулалтад оруулан сургууль, сум, аймгийн түвшинд хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангах, хүүхдийн оролцоо, өөрийн удирдлагын байгууллагад хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах

1.3 Хүүхэд, өсвөр үеийнхний санал бодлыг сонсох, шийдвэр гаргах түвшинд хүргэх арга хэмжээг сар бүр тогтмол зохион байгуулах, үр дүнг тайлагнаж ажиллах

1.4 Хүүхэд, өсвөр үеийнхний дунд үе тэнгийн сургагч багш бэлтгэх ажлыг мэргэжлийн бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулах

1.5 Хүүхэд, гэр бүлийн гишүүдэд зөвлөн туслах ажлыг аймаг, сум, сургуулийн хэмжээнд тэгш хүртээмжтэй болгох

1.6 Үе тэнгийнхний дээрэлхэлт, хүчирхийлэл, дарамтыг арилгах, хүүхдэд эерэг хандлага, эрүүл, зөв зан үйлийг хэвшүүлэх ажлыг Боловсрол, шинжлэх ухааны газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Соёл урлагийн газар зэрэг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах

1.7 Өрх, гэр бүлд чиглэсэн ажлыг талуудын оролцоотой зохион байгуулж, эцэг, эхчүүдийн хариуцлага, оролцоог нэмэгдүүлэх

1.8 "Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам"-ыг мөрдүүлэх, хяналт тавих

ХОЁР. Боловсрол, шинжлэх ухааны газарт

2.1 Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт, үнэлгээ хийж, зөрчил дутагдлыг арилгуулах

2.2 Үдийн цай хөтөлбөрт хамрагддаггүй ахлах ангийнханд зориулсан эрүүл бүтээгдэхүүн, хүнсээр үйлчлэх цэгийг сургууль дээр бий болгох

2.3 Ерөнхий боловсролын сургуулиудад сэтгэл зүйчийг үе шаттайгаар ажиллуулах боломжийг эрэлхийлж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах

2.4 Багш ажилтнуудын харилцаа хандлага, ёс зүйг дээшлүүлэх ажил зохион байгуулах (хүүхдийн дүнг ил зарлахгүй байх, хувийн нууцыг хадгалах, үлгэр дуурайлал үзүүлэх, анги хооронд харьцуулах... гэх мэт). Энэ чиглэлээр алдаа дутагдал гаргаж, хүүхдийн эрхийг зөрчсөн багш, албан тушаалтанд зохих хариуцлагыг хүлээлгэх

2.5 Ерөнхий боловсролын сургууль, Политехник коллежийн дотуур байрны орчин, нөхцөлд хяналт хийж, хүүхдэд ээлтэй байдлыг хангуулах арга хэмжээ авах

2.6 Суралцагчдын биеийн тамирын хичээлд орох нөхцөл, боломжийг анхаарч, эрэгтэй, эмэгтэй хүүхдийн хувцас солих өрөөг сургуулиудад бий болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах

2.7 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх, хүүхэд ялгаварлан гадуурхагдах, боловсролын үйлчилгээнээс орхигдох байдлыг таслан зогсоох арга хэмжээ авах

2.8 Боловсрол, сургалтын байгууллагын орчинд хэрэгжих хүүхэд хамгааллын бодлого, журмын хэрэгжилтэд үнэлгээ хийж, үр дүнтэй хангуулах, сургууль, дотуур байрны орчинд хүүхдийн эрх ашиг зөрчигдөх, эрсдэлт өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах

2.9 Сургуулийн эмчийн ажиллах орчин нөхцөл, ажлын чанар, хүртээмжийг сайжруулж, анхны тусламжийн хэрэгслийг бүрдүүлэх

2.10 Сурагчийн нас бие, сэтгэл зүйн онцлог хэрэгцээнд тулгуурласан орчны тохижилтыг бий болгох

2.11 Шинжлэх ухааны туршилт хийх боломжтой тоног төхөөрөмж бүхий анги танхимыг сургуулиудад үе шаттайгаар бий болгох ажлыг холбогдох газарт уламжилж, шийдвэрлүүлэх

2.12 Сургуулийн номын санг тохижуулах, номын хангалтыг баяжуулах, хүүхэд хөгжлийн өрөөтэй болох

2.13 Ариун цэврийн өрөөний стандартыг хангах, охидын ариун цэврийн өрөөний тохижилтыг сайжруулах (түгжээ, суутуур, ариун цэврийн цаас, саван... гэх мэт)

2.14 Мэргэжлийн багш, ажилтны нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр салбарын хэмжээнд бодлого барьж, хэрэгжилтийг хангаж ажиллах (Математик, түүх нийгэм, зураг технологи, хөгжмийн мэргэжлийн багш, сэтгэл зүйч... гэх мэт)

2.15 Түрээсийн сурах бичгийн тоог нэмэгдүүлэх талаар холбогдох газарт уламжилж, шийдвэрлүүлэх

2.16 Дугуйлан, секцийн тоо, чанар болон хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд асуудлыг хүүхдийн төлөө зөвлөлийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлэх

2.17 Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн А/288 дугаар тушаалын дагуу хичээлээс гадуурх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр батлан хэрэгжилтийг ханган ажиллах (Хууль эрх зүй, нийгмийн харилцаа, сэтгэл хөдлөл, ёс зүй, хувь хүний үр чадварт суралцах)

2.18 Үнийн хөөрөгдөлт, эдийн засгийн байдлаас хамааран дүрэмт хувцас иж бүрнээр өмсөхийг амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн хүүхдүүдээс шаардахгүй байх

ГУРАВ. Эрүүл мэндийн газарт

3.1 Хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл дадал, зан үйл, хэв маягийг хэвшүүлэх сургалт, арга хэмжээг салбар дундын оролцоотой зохион байгуулж, тэдэнд ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх

3.2 Хүүхдүүдийн дунд зонхилон тохиолддог өвчлөл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг оновчтой хүргэх ажлыг хэрэгжүүлэх

3.3 Өсвөр үе, зорилтот бүлгийн залуучуудад нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөө, үйлчилгээ хүргэх ажлын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, охидын төрөлт, хүсээгүй жирэмслэлт, аюултай үр хөндөлт, бэлгийн замаар дамжих халдварын тохиолдлыг бууруулахад нөлөөллийн арга хэмжээ авах

3.4 Сумын эрүүл мэндийн төвүүдийг шүдний эмчээр хангах ажлыг бодлогын хэмжээнд үе шаттайгаар зохион байгуулах

ДӨРӨВ. Биеийн тамир, спортын газарт

4.1 Боловсрол, шинжлэх ухааны газар Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран хүүхэд, өсвөр үеийнхний дунд зохион байгуулах биеийн тамир, спортын арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх, тэдний бие

бялдын хүмүүжил, төлөвшил, боловсрол, соёлыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, уралдаан, тэмцээнийг үе шаттай тогтмол зохион байгуулах

4.2 Хүүхэд бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлэх, нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөл боломжийг аймгийн хэмжээнд бүрдүүлж, нэмэгдүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллага, холбоодын оролцоотой зохион байгуулах

4.3 Биеийн тамир, спортоор хичээллэж, өөрийгөө хөгжүүлэн амжилт гаргасан хүүхэд, залуучуудыг сурталчилж, тэднийг даган дуурайх хүсэл тэмүүллийг бусад хүүхдүүдэд олгох үйл ажиллагаа, нөлөөллийн арга хэмжээ хэрэгжүүлэх

4.4 “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам”-ыг мөрдөх

ТАВ. Соёл, урлагийн газарт

5.1 Түүх, соёлын өв уламжлалыг хүүхэд, өсвөр үеийнхэнд түгээн дэлгэрүүлэх, нутгийн ардын урлаг, ёс заншил, уламжлалт зан үйлийг сэргээн хөгжүүлэхэд санаачилга гаргаж, холбогдох арга хэмжээг салбар дундын оролцоотой зохион байгуулах

5.2 “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам”-ыг мөрдүүлэх, хяналт тавих

5.3 Соёл урлагаар дамжуулан хүүхдийг хүмүүжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх бодлогын арга хэмжээг эцэг эх, асран хамгаалагчидтай зөвшилцөн, хамтран зохион байгуулах

5.4 Нийтийн номын сангийн ажиллах хуваарийг хүүхдүүдэд ээлтэй байдлаар зохицуулалт хийх

ЗУРГАА. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт

6.1 Халамжийн үйлчилгээнд хамрагддаг зорилтот гэр бүл, хүүхдийн судалгааг нарийвчлан шинэчилж, тухайн өрхүүдэд чиглэсэн хөгжлийн үйлчилгээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах

6.2 Хүүхэд, өсвөр үеийнхэнд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран шинэлэг байдлаар хэрэгжүүлэх

ДОЛОО. Цагдаагийн газарт

7.1 Хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, хохирохоос урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг зохион байгуулах

7.2 Хүүхдийн дэргэд архидан согтуурах, хүүхдэд бэлгийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн гаралтыг бууруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттай зохион байгуулах

7.3 Өсвөрийн сэргийлэгч бүлгэмийн хүүхдүүдтэй хамтран хүүхдэд согтууруулах ундаа, тамхи худалдан борлуулдаг зөрчлийг судалж, мэргэжлийн

байгууллагуудтай хамтран дэлгүүр, худалдаа үйлчилгээний төв, газруудад үзлэг, шалгалт зохион байгуулж хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгах, таслан зогсоох арга хэмжээ авах

7.4 Цахим орчин дахь худал, хуурмаг мэдээлэл, түүний хор уршгийн талаар урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажил зохион байгуулах.

7.5 Хүүхдүүдэд хууль, эрх зүйн мэдлэг олгох чиглэлээр сургалт зохион байгуулах

7.6 Хүүхдээс мэдүүлж буй гэмт хэргийн шинжтэй дуудлагыг шуурхай хүлээн авч, хянан шийдвэрлэх, холбогдох арга хэмжээ авах

НАЙМ. Сумын Засаг дарга нарт

8.1 Хүүхдийн хөгжлийг дэмжсэн хэтөлбөр, сонгон, секц, дугуйлан, уралдаан тэмцээний арга хэмжээ, үйлчилгээг сумын хэмжээнд тогтмол зохион байгуулж, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

8.2 Сургуулийн орчны тохижилт, хүүхдэд ээлтэй, аюулгүй байдлыг хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх. (Хичээлийн болон дотуур байрны хүртээмж, цэвэр ус, ариун цэврийн байгууламж, камержуулалт, ая тухтай байдал, номын сан, үдийн цай, цайны газар, итгэлтэй утас... гэх мэт)

8.3 Гэрээс сургууль хүртэлх зай, зам, талбайн аюулгүй байдлыг хангах, дэд бүтцийг сайжруулах, хүүхдэд учрах эрсдэлийг таслан зогсоох, бууруулах ажлыг хэрэгжүүлэх. (Гэрэлтүүлэг, эзэнгүй нохойн устгал, нийтийн тээврийн үйлчилгээ, халуун ус, хог хаягдал, хүнсний эрүүл, аюулгүй байдал, хүүхэд тээврийн хэрэгсэл жолоодох, хүүхэд ундны худгаар үйлчлүүлэхэд аюулгүй байдлыг хангах, өвлийн улиралд хальтарч гэмтэхээс сэргийлж, тогтсон мөсийг арилгах... гэх мэт)

8.4 Хүүхдийн чөлөөт цагийг зөв бословсон өнгөрөөх орчин, нөхцөлийг сумын хэмжээнд үе шаттай нэмэгдүүлэх арга хэмжээ авах (интернэт орчин бүхий номын сан, ногоон байгууламж, фитнес клуб, тоглоомын талбай, унадаг дугуйн зам, хүүхэд хөгжлийн төв... гэх мэт)

8.5 Сургууль дахь хүүхдийн оролцоо, өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулж буй арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах

8.6 Хүүхдийн элчийг сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулж, холбогдох журмын дагуу үйл ажиллагаа явуулах нөхцөл, боломжоор ханган хамтарч ажиллах

8.7 "Соёл урлаг, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам"-ын хэрэгжилтийг сум, орон нутагтаа хангуулж, аймаг, улс, олон улс, тив, дэлхийн уралдаан, тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлж ажиллах

8.8 "Хүүхдийг сонсох өдөр"-ийг сар бүрийн 01-ний өдөр зохион байгуулж хэвших, санал, хүсэлтийг үе шаттай шийдвэрлэж, биелэлтийн явцын талаарх мэдээллийг дараа сарын дотор иргэд, хүүхдүүдэд танилцуулдаг байх (сар бүрийн 10-ны дотор Гэр бүл, хүүхэд залуучуудын газарт тайлагнах)

8.9 Стандартын шаардлага хангахгүй, хүүхэд гэмтэх эрсдэлтэй сургуулийн спорт заалны шалыг сольж, сайжруулах

8.10 Хог ангилах савтай болж, тоог нэмэгдүүлэх

8.11 Унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангахад анхаарч, хүүхэд бүр эрсдэлийн даатгал хийлгэх шаардлагыг хэрэгжүүлэх

8.12 "Зөгийн үүр" арга хэмжээний хүрээнд сумын эрүүл мэндийн төвийг шүдний эмчээр хангах асуудлыг холбогдох газартай хамтран яаралтай зохион байгуулах

ЕС. Хүүхэд, өсвөр үеийнхэнд

9.1 Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөж, өөрийн оюун ухаан, авьяас, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэхэд бүтээлчээр суралцах

9.2 Бусдын эрхийг зөрчихгүй байх, нийтийн дунд биеэ зөв авч явах, аливаад зөвөөр үлгэрлэх, хогийг ил задгай хаяхгүй байх, бусадтай эрх тэгш харилцах, шүд, гараа тогтмол угаах, бусадтай мэндлэх, зөв зан үйлийг өөртөө хэвшүүлэх

9.3 Гэр бүл, нийгмийн болон цахим орчинд өөрийгөө аюул, эрсдэлд өртөхөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх, амьдрах ухааны арга барил, чадварт суралцах

9.4 Аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлт нөхцөлд өртөж болзошгүй болон өртсөн найз нөхөд, хүүхдүүдийн талаарх мэдээллийг 108 утас, анги удирдсан багш, сургуулийн нийгмийн ажилтан болон Цагдаагийн байгууллагад нэн даруй мэдээлэх

Зохион байгуулсан ажил, арга хэмжээний үр дүнг 2023 оны 10 дугаар сарын 01-ний дотор Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт тайлагнахыг сумдын Засаг дарга болон холбогдох байгууллагын дарга нарт, тайлан мэдээг нэгтгэн Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Уртнасан)-д, албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ